



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 7/253

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” жил болгон зарлах тухай 07/04 тогтоол, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 07/08 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” зорилтот жилийн хүрээнд Бат-Өлзий сум дахь Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрын өргөтгөлд усалгааны эх үүсвэр бүрдүүлэхэд 10,350,000 (арван сая гурван зуун тавин мянга) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулах 10,350,000 (арван сая гурван зуун тавин мянга) төгрөгийг аймгийн зорилтот жилийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Г.Баясгалан), Бат-Өлзий сумын Засаг дарга (С.Амгалан) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0555

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 19 ны өдрийн
05 дугаар захирамжийн
хавсралт

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум дахь Сум дундын Ойн ангийн
мод үржүүлгийн газрын өргөтгөлд усалгааны эх үүсвэр бүрдүүлэхэд
шаардагдах зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нийт үнэ (мян.төг)
1.	Усалгааны бороожуулах систем	ширхэг	1	2,700,000
2.	Дуслын усалгааны систем	ширхэг	1	5,370,000
3.	Усны сав	ширхэг	2	900,000
4.	Усны насос	ширхэг	2	720,000
5.	Усалгааны шланг	боодол	5	660,000
Дүн				10,350,000

-оОо-